

СТАНДАРТ НООС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар № 01/2018.

2018.04.10.

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны
үр дүнгийн тухай

“Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлын хэлэлцсэн асуудал, компанийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн, хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Стандарт ноос” ХК нь албан ёсоор бие даасан үйл ажиллагаагаа эхлээгүй боловч “Улаанбаатар хивс” ХК-ийн зүгээс хөрөнгө, санхүүжилт гарган ажиллаж байгааг сайшаан тэмдэглэж, Засгийн газрын зээл, тусламж болон гадаад дотоодын бусад хямд эх үүсвэрээр компанийн ноос угаах үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж, 2018 онд үйл ажиллагааг нь эхлүүлж ажиллахыг компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.



ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ДАРГА :

Л.ЦЭВЭЭНРАВДАН

СТАНДАРТ НООС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар № 02/2018.

2018.04.10.

Улаанбаатар хот

Компанийн төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүдийг батлах тухай

“Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлын хэлэлцсэн асуудал, компанийн төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд :

- Бархасын Батболд
- Баттулгын Баясгалан
- Цоодолын Зоригт
- Лхамсүрэнгийн Цэвээнравдан
- Ёндонжамцын Энхтөр
- Зоригтын **Эрдэнээ**

2. Компанийн тухай хуулийн 75-81 дүгээр заалтууд болон Компанийн дүрмэнд тусгагдсан эрх үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлж, ТУЗ-ийн дэргэдэх хороодуудыг зохих журмын дагуу зохион байгуулан 2018 оны төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлж ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.



ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ДАРГА :

Л.ЦЭВЭЭНРАВДАН

СТАНДАРТ НООС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар № 03/2018.

2018.04.10.

Улаанбаатар хот

Компанийн төлөөлөн удирдах
зөвлөлийн хараат бус гишүүдийг
батлах тухай

“Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлын хэлэлцсэн асуудал, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд :

- Лувсангийн Итгэлт
- Гансүхийн Оюун-Эрдэнэ
- Болдын Уранбилэг

2. Компанийн тухай хуулийн 75-81 дүгээр заалтууд болон Компанийн дүрмэнд тусгагдсан эрх үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлж, 2018 оны төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлж ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.



ХУРЛЫН ТӨРГҮҮЛЭГЧДИЙН

ДАРГА :

Л.ЦЭВЭЭНРАВДАН